

**ХҮНИЙ НӨӨЦИЙН ХЭЛТСИЙН ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ ЭРДЭНЭБАТЫН ДОЛГОРЖАВЫН
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин		Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь		
			Суурь түвшин	Хүрэх түвшин					
			1	2	3	4	5	6	7
Зорилт 4: Соён гэгээрүүлэх									
1.	Гаалийн байгууллагын албан хаагчдын хувийн хэргийн хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж хэрэгжүүлэх	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	90%	1. Албан хаагчдын хувийн хэрэгт баяжилт хийсэн байна 2. Хувийн хэргийн тооллогын мөрөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний биелэлтийг хангуулсан байна.	Гаалийн ерөнхий газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/629 дугаар тушаалаар хувийн хэрэгт тооллого хийх ажлын хэсэгт томилогдон ТА3-ийн 2022 оны 600 дугаар тушаалаар батлагдсан "Хувийн хэрэг хөтлөх журам"-д заасан бүрдлийн дагуу гаргасан 51 багана бүхий эхсэл хүснэгт нийт 159 албан хаагчид хамаарах хувийн хэргийн хуудас бүрийг нэг бүрчлэн тоолж судалгааг хөтөлж, хариуцсан албан хаагчид нэгтгүүлсэн. - Нийт тоологдсон судалгааны нэгтгэлээс төрийн үйлчилгээний албан хаагчид хамаарах нэгтгэл дүнг тусад нь гаргаж судалгааны нэгтгэлийг гаргаж, ажлын хэсгийн нарийн бичигт өгсөн. - Албан хаагчдын хувийн хэргийн тооллогын нэгдсэн судалгаанаас /Серп/ 456 албан хаагчийн цахим анкетын төлөв, мэдээлэл орсон төлөв болон албан тушаалын нэршлээр тулгалт хийж судалгаа гаргаж, холбогдох албан хаагчид өгсөн. - Ажлын хэсгийн нарийн бичигтэй хамтран	2025.01.01-2025.06.10	93%		

					<p>танилцуулгыг боловсруулж, 8 удаа зөвлөмж чиглэл авсны дагуу эцэслэн баталгаажуулсан.</p> <p>- Хувийн хэргийн тооллогын үр дүнг сайжруулан ажлын төлөвлөгөөний төсөлд ажлын хэсгийн гишүүдээс санал авч боловсруулан 4 удаа хянуулж, зөвлөмж авч боловсруулан танилцуулж 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдөр эцэслэн баталгаажуулсан.</p> <p>- Төрийн тусгай албан хаагчдын хувийн хэргийг харьяа газар, хороодоос татахтай холбоотой анхааруулга, зөвлөмж, зааварчилгааг хувийн хэрэг хариуцсан архивын ажилтантай хамтран 3 удаа хянуулан зөвлөмж авч боловсруулж эцэслэн баталгаажуулсны дагуу харьяа газар, хороодод 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 01-1/636 тоот албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>- Харьяа газар, хороодоос хувийн хэргийг татахтай холбоотой Говь-Алтай аймаг дахь гаалийн хорооны 15, Сүхбаатар аймгийн Бичигт дэх гаалийн хорооны 17, Баян-Өлгий аймаг дахь гаалийн газрын 38, Сайншанд дахь гаалийн газрын 36, Гашуун сухайт дахь гаалийн газрын 65, Сэлэнгэ аймаг дахь гаалийн газрын 187 төрийн тусгай албан хаагчдын цахим хувийн хэргийн материалыг хүлээн авч 27 албан хаагчид холбогдох хувийн хэргийн материалыг хянаж, баяжуулалт хийж, тус бүр товьёг үүсгэн баталгаажуулж хийсэн.</p>		
Зорилт 3. Ногоон хөгжлийг дэмжиж, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх							
2.	Гаалийн байгууллагын албан сургалт, нөхцөл, нийгмийн	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	90%	1.Төлөвлөгөөг батлуулсан	ГЕГ-ын даргын 2024 оны А/717 дугаар тушаалаар батлагдсан "Гаалийн байгууллагын албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр"-ийн хэрэгжилтийн хангуулахаар харьяа	2025.01.01-2025.06.10	100%

<p>Баталгааны хөтөлбөр түүнийг хэрэгжүүлж, төлөвлөгөөний биелэлтийг хариуцан ажиллах</p>		<p>Байна.</p> <p>2. Төлөвлөгөөний биелэлтийг хангуулж, хэрэгжилтэд хяналт тавих</p>	<p>газар, хороодод 2025.01.09-ний өдрийн 01-1.1/112 албан бичгээр хүргүүлж, хэрэгжүүлж ажиллах талаар чиглэл өгсөн ба ГЕГ-ын хэмжээнд 2025 онд хэрэгжих төлөвлөгөөний төслийг ГЕГ-ийн нэрж, дэргэдэх байгууллагуудад 2025 оны 01 дүгээр сарын 01 дүгээр сарын 08-ны өдрийн 01120/1 тоот дотоод зурвасаар хүргүүлж санал авсан. Мөн албан хаагчдын хэрэгцээ, шаардлагыг тодорхойлохоор Google Forms дээр асуулга бэлдэж ГУАБ, ГУБ, ТУАХ-ыг хамруулан 2025 оны 02 дугаар сарын 26, 27-ны өдрүүдэд саналыг авч нэгтгэн, дүгнэлтийг нэгжийн удирдлагад танилцуулсны дагуу ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангуулах зорилтын хүрээнд 12 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдөр батлуулсан ба төлөвлөгөөний 7 хоног, сар бүр, улирлаар хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлтийг харьяалах нэгжээс авч, ажилласан. Мөн гаалийн газар, хороодын төлөвлөгөөг авч нэгтгэн, эхний хагас билийн биелэлтийг авах талаар 2025.05.22-ны өдрийн 01-1.1/2156 тоот албан бичгээр хүргүүлсний дагуу 13 гаалийн газар, хорооноос албан бичгээр биелэлтийг баталгаажуулан ирүүлсэн. Баталгаажуулан ирүүлсэн тайланг Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан журамд заасан маягт хүснэгтийн дагуу байгууллагын онцлогт тохируулан боловсруулж, нэгтгэн ажиллаж байна. Мөн 2026 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төсвийн төсөөллийг гарган нэгжийн удирдлагад хянуулан зөвлөмж авч ажилласан.</p> <p>Сургалт хөгжлийн үйл ажиллагааны чиглэлээр:</p> <ul style="list-style-type: none"> - Удирдлагын академийн богино хугацааны болон мэргэшүүлэх багц сургалтад хамрагдах албан хаагчдын хүсэлтийг бүртгэлд авч нэгтгэсэн ба 2019, 2020, 2021, 2022, 2023, 2024, 2025 онд хамрагдсан албан хаагчдын судалгааг
--	--	---	---

			<p>хаагчид холбогдох захиалгат сургалт явуулах тухай гэрээг баталгаажуулан Удирдлагын академируу явуулах ажлыг зохион байгуулсан.</p> <p>- Гаалийн байгууллагын 94 албан хаагчийг 2025 онд Удирдлагын академийн мэргэшүүлэх багц сургалтад хамруулахаар албан бичгээр хүргүүлсэн ба хамрагдсан албан хаагчдын судалгааг гаргахаар 64 албан хаагчтай утсаар 1-2 удаа холбогдож мэдээллийг авсан</p> <p>- Харьяалах 2 нэгжээс 4 албан хаагчийг Удирдлагын академийн сургалтад хамруулах тухай ирүүлсэн саналыг хүлээн авч, судалгаанд нэгтгэн, шаардлага хангаж байгаа эсэх судалгааг гаргасан.</p> <p>Тус хөтөлбөрийн нийгмийн баталгаа</p> <p>- Албан хаагчдыг гэнэтийн ослын даатгалд хамруулах, даатгалын үйлчилгээ авах зорилгоор 2025.01.14-ний өдрийн А/07 дугаар тушаалаар батлагдсан "Үнэлгээний хороо байгуулах тухай" ажлын хэсэгт орж 01 дүгээр сарын 22, 02 дугаар сарын 24, 03 дугаар сарын 19-ний өдрүүдэд хуралдаж, төндэрт ирүүлсэн материалыг шалган, хамгийн сайн шаардлага хангаж материал ирүүлсэн "Хаан даатгал" ХХК-ыг шалгаруулж ажилласан ба тус ХХК-аас 2025.05.09-ний өдөр гэнэтийн ослын даатгалын талаарх мэдээлэл өгөх үйл ажиллагааг зохион байгуулсан ба мэдээлэл авч оролцсон.</p> <p>- Гаалийн байгууллагын ахмадын хорооны анхдугаар хуралдаан 2025.04.15-ны өдрийн 09:30-02:10 цагийн хооронд Улаанбаатар хот дахь гаалийн газрын хурлын танхимд болсон ба тус хуралд хурлын тэмдэглэл болон зураг, бичлэг хийж ахмадуудыг дэмжиж ажилласан.</p>	

			<p>хаагчдын хамрагдалтын мэдээг авч газар, хороодод хамрагдалтыг нэмэгдүүлэх тухай чиглэл өгч, нийт 1235 албан хаагчдыг хамруулж ажилласан.</p> <p>- Мөн "Хэрэглээний сэтгэл судлалын хүрээлэн" ТББ-тай 2025.06.06-ны өдөр уулзалт зохион байгуулж, "Сэтгэл зүйн үнэлгээний нэгдсэн үр дүнтэй танилцан, цаашид хамтран ажиллах эсэх талаар хэлэлцэн тус байгууллагын үйл ажиллагаатай танилцаж, сэтгэл зүйн эрүүл мэндийг хамгаалах өдөрлөг зохион байгуулж, хамтран ажиллахаар болсон.</p> <p>Төлөвлөгөөний 2, 12 дахь арга хэмжээний хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> - Хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор 2025.04.10 - 2025.04.29 - ны өдрийг дуустал өдөр 2 цаг буюу нийт 26 цагийн гар бөмбөг, сагсан бөмбөгийн бэлтгэл хийж хамрагдсан. Мөн 14 хоногт 1 удаа байгууллагын спорт зааланд дасгал хөдөлгөөн хийж хэвшсэн. - Хамт олны чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, баг хамт олны дунд найрсаг харилцааг дэмжих зорилгоор ГЕГ-ын Спорт хамтлагаас байгууллагын 5 төрөлт спортын тэмцээнийг зохион байгуулсан ба сагсан бөмбөг, гар бөмбөгийн тэмцээнд 2025 оны 03 дугаар сарын 20, 21-ний өдрүүдэд хэлтсийн хамт олноороо оролцож 2 дугаар байранд орж, амжилттай оролцсон. - Мөн хамт олны найрсаг харилцааг дэмжих, идэвхитэй хөдөлгөөнд уриалах, спортлог хэв маягийг сурталчилах зорилгоор уламжлал болгон зохион байгуулдаг "Гаалийн цом-2025" спортын арга хэмжээнд сагсан бөмбөг, гар бөмбөгийн төрөлд амжилттай оролцож, баг 	
--	--	--	---	--

			<p>Хамт олноороо цом авсан.</p> <p>Төлөвлөгөөний 10 дахь арга хэмжээний хүрээнд:</p> <p>- "Харилцан хүндэлбэ" аяныг Жендэрийн үндэсний хорооноос зарласантай холбогдуулан албан хаагчдыг "Та бүхэн бие биетэйгээ өглөө бүр мэндэлж, амжилт хүсэж, талараж, сайн сайхныг хүсэж, ерөөж харилцан хүндэтгэлтэй хандан эерэг байхыг уриалж байна" гэсэн зураг хуудсыг боловсруулж "Бид гаалийнхан", "Гаалийн албан хаагчдын мэдээлэл солилцох албан ёсны групп"-д тус тус байршуулан уриалсан. Мөн газар хороодыг тус аянд нэгдүүлж, зохион байгуулалтаар хангаж, тайланг нэгтгэн Сангийн яамны Жендэрийн салбар зөвлөлд Volgotmaa.ba@mof.gov.mn мэйл хаягаар хугацаанд хүргүүлэн ажилласан.</p> <p>- Албан хаагчдад жендэрийн тухай ойлголт, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор 05 дугаар сарын 23, 25-ны өдрүүдэд "Жендэр гэж юу вэ", 05 дугаар сарын 27-ны өдөр "Ажлын байрны бэлгийн дарамтын тухай ойлголт, 06 дугаар сарын 04-ний өдөр "Ажлын байрны бэлгийн дарамт үг, үйлдлээр илрэх нь" зураг хуудасыг боловсруулж "Гаалийн байгууллагын албан хаагчдын албан ёсны фэйсбүүк хуудас"-т байршуулж, харьяа гаалийн газар, хороодын дотоод сүлжээнд байршуулан түгээлгэхээр чиглэл өгч ажилласан.</p> <p>- "Жендэр гэж юу вэ", "Жендэрийн эрх тэгш байдал", "Жендэрийн хэвшмэл үзэл", "Ажлын байрны бэлгийн дарамт"-ын талаарх ойлголт өгөх зорилгоор 05 дугаар сарын 14, 15, 23, 27-ны өдрүүдэд спаркаар албан хаагчдад нийтэлж, хүргэсэн.</p> <p>- Нийт албан хаагчдад Жендэрийн тухай ойлголт өгөх зорилгоор зурагт хуудас бэлтгэн Гаалийн албан хаагчдын албан ёсны мэдээлэл солилцох групп, харьяа 19-н гаалийн газар, хорооны дотоод</p>	
--	--	--	---	--

				<p>цахим сүлжээ, спаркаар тус тус түгээсэн</p> <p>- Жөндөрийн эрх тэгш байдлыг хэрэгжүүлэхэд шаардлагатай 2026 оны төсвийн төсөөлөлийг боловсруулан хянуулж, зөвлөмж авсан.</p> <p>- Гаалийн байгууллагын жөндөрийн эрх тэгш байдлыг хангуулах ажлын 2025 оны төлөвлөгөөний төслийг боловсруулж, нэгжийн удирдлагаар 2 удаа хянуулж, зөвлөмж авч боловсруулан Жөндөрийн дэд салбар зөвлөлийн даргад цахимаар болон цаасаар танилцуулан хянуулж, зөвлөмж авч ажилласан.</p>			
3.	<p>Жөндөрийн дэд салбар зөвлөлийн ажиллагааны төлөвлөгөөг батлуулж, хэрэгжүүлэх</p>	<p>Хэрэгжилт, гүйцэтгэлээр</p>	<p>90%</p>	<p>1. Төлөвлөгөөг батлуулсан байна.</p> <p>2. Төлөвлөгөөний биелэлтийг хангуулж, хэрэгжилтэд хяналт тавих</p>	<p>Гаалийн байгууллагын жөндөрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:</p> <p>- Сангийн яамны жөндөрийн салбар зөвлөлөөс ирүүлсэн "Ажлын байрны жөндөрийн мэдрэмжийг үнэлэх шалгуур үзүүлэлтийн маяг"-ын дагуу үнэлгээг 6 бүлгийн хүрээнд 37 үзүүлэлтийг чанарын болон тоон утгаар илэрхийлэн заасан хугацаанд буюу 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн дотор боловсруулан Volgotma_ba@mof.gov.mn хаягаар хүргүүлсэн.</p> <p>- Жөндөрийн үндэсний хорооноос "Харилцан хүндэлбэ" аяныг зарласантай холбогдуулан албан хаагчдыг "Та бүхэн бие биетэйгээ өглөө бүр мэндэлж, амжилт хүсэж, талараж, сайн сайхныг хүсэж, ерөөж харилцан хүндэтгэлтэй хандан зэрэг байхыг уриалж байна" гэсэн зураг хуудас болон газар, хороодын аянд нэгдсэн тухай видео бичлэгийг "Бид гаалийнхан", "Гаалийн албан хаагчдын мэдээлэл солилцох албан ёсны групп"-д тус тус байршуулан сурталчилж, мэдээ мэдээлэл түгээсэн.</p> <p>- Харьяа 19 газар, хороодын жөндөр хариуцсан албан хаагчдын мэдээлэл солилцох цахим групп үүсгэж, мэдээ, мэдээлэл өгч, "Харилцан хүндэлбэ" аянд нэгдэхийг уриалсан ба</p>	<p>2025.01.01- 2025.06.10</p>	<p>95%</p>

				<p>холбогдох 18 газар, хороодын тайланг нэгтгэх авч Сангийн яамны Жендэрийн салбар зөвлөлд заасан хугацаанд буюу 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдөр Volgotmaa.ba@mof.gov.mn мэйл хаягаар хургуулсан.</p> <ul style="list-style-type: none"> - Жендэрийн дэд салбар зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг холбогдох хууль, дүрэм журам, Жендэрийн үндэсний хороо, Сангийн яамны Жендэрийн салбар зөвлөлийн 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулах зорилгоор судалгаа хийж боловсруулж байна. - Харьяа газар, хороодын жендэрийн асуудал хариуцсан албан хаагчдыг Удирдлагын академийн "Жендэрийн мэдрэмжтэй харилцаа холбоо" сэдэвт цахим сургалтад 29 албан хаагчийг хамруулж, "Жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлт, төсөвлөлт" сэдэвт сургалтад хамруулах ажлыг зохион байгуулж байна. Мөн газар, хороодын тайлан мэдээ өгсөн, сургалтад хамрагдсан талаарх судалгааг хөтлөн ажиглаж байна. - Жендэрийн дэд салбар зөвлөлийн даргаас 2025.04.04-ний өдөр ажлын чиглэл авч ажилласан. - Хөдөлмөрийн дотоод журамд нэмэлт өөрчлөлт оруулах ажлын хэсэгт 2025.04.29-ний өдөр Жендэрийн эрх тэгш байдлыг хангуулах чиглэлээр ажил олгогч, ажилтны эрх үүрэг, гомдол мэдээлэл хүлээн авах талаар холбогдох 32 зүйл, заалт бүхий саналыг танилцуулсан. <p>Удирдлагаас нийт 109 өргөдөл, хүсэлт, албан бичиг цохсоны дагуу холбогдох арга хэмжээг авч, зохион байгуулан хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна.</p> <ul style="list-style-type: none"> - ГЕГ-ын нэгж, дэргэдэх байгууллагаас 50 албан бичиг ирсний 45-ийг үйл ажиллагаанд нэгтгэн авч, холбогдох арга хэмжээг авч, хуулийн хугацаанд шийдвэрлэсэн ба 5 албан бичгийг хуулийн 	2025.01.01-2025.06.10	100%
4.	Хүний нөөцийн чиглэлээр албан хаагч, иргэдээс хандсан өргөдөл, гомдлыг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх	Хэрэгжилт, гүйцэтгэлээр , хувиар	100 %	Хууль, журмын дагуу заасан хугацаанд шийдвэрлэсэн байна.		

					хугацаанд шийдвэрлэхээр ажиллаж байна. - Гаалийн газар, хороодоос 38 албан бичиг ирсний 22-ийг үйл ажиллагаанд нэгтгэн авч, холбогдох арга хэмжээг авч, хуулийн хугацаанд шийдвэрлэсэн ба 16-г хуулийн хугацаанд шийдвэрлэхээр ажиллаж байна. - АТГ, ДХИС, УА, НЗХАШШ-ээс 9 албан бичиг ирснийг хуулийн хугацаанд шийдвэрлэн ажилласан. - Ахмадын хорооноос ирүүлсэн 4 албан бичиг ирсний 2-ийг Хуулийн хэлтэстэй хамтран хуулийн хугацаанд шийдвэрлэсэн ба 2-ийг хуулийн хугацаанд шийдвэрлэхээр ажиллаж байна.		
5.	Хүний нөөцийн үйл ажиллагаанд хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, эрх зүйн актыг мөрдөж ажиллах	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	100 %	Үйл ажиллагааг хууль дүрэм журмын дагуу зөрчилгүй гүйцэтгэсэн байна.	Тайлант хугацаанд нэгжийн удирдлагаас хувиарлан өгсөн ажлын чиг үүргийг хэрэгжүүлэхдээ холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг үйл ажиллагаандаа баримтлан ажиллаж байна.	2025.01.01-2025.06.10	100%
6.	Гаалийн байгууллагаас гарсан ахмадуудыг бүртгэх, судалгаанд хамруулах, холбогдох нэгжүүдтэй хамтран арга хэмжээг зохион байгуулах	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	100 %	Ахмадын бүртгэлийг тухай бүр шинэчлэн хөтөлж, дэмжлэг үзүүлсэн байна.	Ахмад настнаас ирүүлсэн 3 хүсэлтийг хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэсэн ба цагаан сарын баярыг тохиолдуулан ГЕГ-ын ахмадын судалгааг шинэчилэн гаргасан ба харьяа, газар хороодын ахмадын судалгааг ЗУГ-аас гаргаж өгсний дагуу СХОГ-т 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдөр 01120/21 тоод догтоод зурвасаар хүргүүлсэн.	2025.01.01-2025.06.10	100%
Зорилт 2. Хууль сахиулах, аюулгүй байдлыг хангах							
7.	Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хэрэгжүүлж ажиллах	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	100 %	Үүрэг даалгаврыг заасан хугацаанд гүйцэтгэж, тайлагнасан байна.	Дараах ажлын хийж гүйцэтгэсэн байна. Үүнд: - Төрийн үйлчилгээний албан хаагчдын "Ажлын байрны тодорхойлолт" боловсруулах ажлын хүрээнд танилцуулгыг бичиж, нэгжийн удирдлагаар 5 удаа хянуулан зөвлөмж, чиглэл авсны дагуу боловсруулалтыг хийж байна. Мөн ажлын байр давхардсан 13 ажлын байрны тодорхойлолтыг боловсруулж, төрийн үйлчилгээний 49 ажлын байрны мэргэжил, боловсрол, мэргэшил, туршлагын судалгааг	2025.01.01-2025.06.10	90%

				<ul style="list-style-type: none"> - гаргаж 2025.05.29-ний өдөр хэлтсийн албан хаагчдаар хянуулж, саналыг авч ажилласан. - Албан хаагчийг гэнэтийн ослоын даатгал, байгууллагын тээврийн хэрэгслийг тээврийн хэрэгслийн болон жолоочийн хариуцлагын даатгалд хамруулах зорилгоор байгуулагдсан "Үнэлгээний хороо"-ны хуралд 2025.01.22, 2025.03.19-ны өдөр сууж, санал өгсөн. - ДХИС-аас зохион байгуулж буй "Хилийн аюулгүй байдалд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам-2025" сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг 2025 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр зохион байгуулахтай холбоотой зарыг албан хаагчдад түгээх зорилгоор 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдөр Сургалтын төвийн даргатай холбогдож чиглэл авч, газар хороодын захиргаа хүний нөөц хариуцсан байцаагч нарт түгээж ажиллах чиглэл өгч, Сургалтын төвийн гаалийн улсын байцаагч Н.Анужинд бичвэрийг боловсруулан өгч "Бид гаалийнхан", "Гаалийн албан хаагчдын мэдээлэл солилцох албан ёсны групп"-д тус тус байршуулсны дагуу тус хурал 3 албан хаагч оролцох хүсэлт гаргасныг холбогдох мэйлээр хүргүүлж, бүртгүүлсэн. - Долоо хоног бүрийн 5 дахь өдөр бүр 4 удаа хийсэн ажлын тайланг гаргаж, холбогдох албан хаагчид өгсөн. - ЧХОУНБГТ-ын цахим хувийн хэрэг хүлээлгэн өгөх тухай, ХШУДАГ-ийн "Гаалийн байгууллагын Жөндөрийн эрх тэгш байдлыг хангуулах ажлын 2024 оны төлөвлөгөөний биелэлтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн тухай албан бичигтэй танилцаж, үйл ажиллагаанд ашиглахаар ажилбарт авч ажилласан - Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн 2025.04.08-ны өдрийн 06/6812, 2025.04.25-ны өдрийн 06/7981 тоот албан бичгийн хариуг хүргүүлэхээр 		
--	--	--	--	--	--	--

					<p>Удирдлагын академийн сургалтад хамруулах тухай ирүүлсэн саналыг хүлээн авч, судалгаанд нэгтгэн, шаардлага хангаж байгаа эсэх судалгааг гаргасан.</p> <p>- Хувиарлан өгсөн 23 албан хаагчийн ерөнхий болон тусгай шалгалт өсөн эсэхийг тодруулах зорилгоор тус бүр 2-3 удаа утсаар холбогдож, ерөнхий, тусгай шалгалт өгсөн баримтыг гаргуулан авч, Төрийн албаны шинэчилсэн найруулгын хүрээнд зөвлөгөө, зөвлөмж өгч ажилласан ба төрийн жинхэнэ албан хаагчаар томилогдсон огноо, албан тушаалын тодорхойлолтод заасан мэргэжил, албан хаагчийн суралцаж төгссөн мэргэжил, ерөнхий, тусгай шалгалт өгсөн огноо, газар, ангилал зэргээр судалгааг гаргаж, ярилцсан тэмдэглэлийг хөтөлсөн.</p> <p>- Захиргааны удирдлагын газраас зохион байгуулсан ГЕГ-ын чиг үүргийн судалгаанд https://forms.gle/9tphHhXh1AUNz3C7 дараах холбоосоор орж өгсөн.</p>		
8.	Ажлын цаг ашиглалтыг хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу дагаж мөрдөх	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	100 %	Холбогдох журмыг мөрдөж, зөрчилгүй ажилласан байна.	<p>Ажиллавал зохих 114 хоногоос ажлын 4 өдрийг Удирдлагын академийн сургалт, ажлын 4 цагийг хүүхдийн School police хийж, ажлын 5 цагийг "Жендэрийн мэдрэмжтэй ажлын байр" сэдэвт хэлэлцүүлэгт оролцож, ажлын 7 цагийг хувийн ажлыг амжуулахад холбогдох журмын дагуу захиргааны чөлөө авсан.</p>	2025.01.01-2025.06.10	100%

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт


Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин		Хүссэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин			

1	2	3	4	5	6	7
1. Удирдлагын академийн сургалтад хамрагдах.	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	2 цахим сургалтад суусан	Сургалт ад хамрагдсан байна.	1. Удирдлагын академис зохион байгуулсан "Байгууллагад зэрэг соёлыг бүрдүүлэх нь" сэдэвт 16 цагийн сургалтад 2025 оны 03 дугаар сарын 13, 14-ний өдрүүдэд танхимаар хамрагдаж Z0545 дугаартай гэрчилгээ авсан. 2. Удирдлагын академис 2025 оны 06 дугаар сарын 04, 05-ны өдрүүдэд "Төрийн байгууллагын сургалт, хөгжлийн хөтөлбөр боловсруулах арга зүй" сэдэвт сургалтад танхимаар хамрагдаж Z1633 дугаартай гэрчилгээ авсан. 3. Удирдлагын академийн Цахим сургалтын багаас зохион байгуулж буй "Жендерийн мэдрэмжтэй төлөвлөлт" сэдэвт цахим сургалтын хүрээнд 11-н модуль багц хичээл /training-mongolia.thinkific.com/-ийг 70 хувийн гүйцэтгэлтэй үзэж, судалсан байна.	2025.01.01 - 2025.06.10	100%
2. Монгол бичгийг бие даан судлах	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	Анхан шатны рүвшний мэдлэг олсон	Мэдлэг чадвар дээшилсэн байна.	1. Удирдлагын академийн доктор Т.Саранчимэгийн Монгол бичгийн https://surgalt.gov.mn/courses/mongol-bichgiyl-khicheel-1-dugeer-sha?id=2589268/ 40 цагийн цахим сургалтын 1 дүгээр шатанд суралцаж байна. 1. ЭБАТ, ГУБ Б.Мөнхтуулын илтгэсэн ХАСХОМ хэрхэн гаргах талаарх сургалтад 2025.01.21-ний өдөр хамрагдаж өөрийн ХАСХОМ-ыг нэг бүрчлэн гаргаж мэдүүлэн, баталгаажуулсан. 2. Захиргааны удирдлагын газраас 2025.01.15-ны өдөр зохион байгуулсан "Гаалийн байгууллагын үнэт зүйлийг тодорхойлох" судалгаанд хамрагдсан. 3. Дотоод хяналт, аюулгүй байдлын хэлтэсээс боловсруулсан "Хууль тогтоомжийн хэрэгжилтэд гарч буй эрсдэлийн судалгаан"-д 2025.01.27-ны өдөр хамрагдсан. 4. Гаалийн албан хаагчдын мэдээлэл ашиглах, судалгаа хийх, төлөвлөгөө боловсруулах чадварын түвшинг тодорхойлох судалгаанд 2025.02.03-ны өдөр саналаа өгсөн. 5. Гаалийн байгууллагын удирдах ажилтны сургалт, зөвлөгөөн-2025 арга хэмжээнд	2025.01.01 - 2025.06.10	100%
3. Шинээр гарсан хууль, тогтоол, журам, зааврыг тухай бүр бие даан судалж, хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх	Хэрэгжилт, гүйцэтгэлээр , сургалтын тоогоор	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	Эрх зүйн мэдлэг дээшилсэн байна.		2025.01.01 - 2025.06.10	100%

					<p>“УДИРДЛАГЫН МАНЛАЙЛАЛ БА БАЙГУУЛЛАГЫН СОЁЛ” сэдвээр илтгэх Удирдлагын академийн Хүний нөөцийн удирдлагын тэнхимийн ахлах багш, доктор Т.Төмөр багшийн боловсруулсан “Гаалийн байгууллагын соёлын зэрэг, сөрөг, хүчтэй, сул зэрэг хэлбэрийг тодорхойлох санал асуулга”-д 2025.02.04-ний өдөр саналаа өгсөн.</p> <p>6. Аж ахуй үйлчилгээний албанаас Монос ХХК-тай хамтран 2025.02.03-ны өдөр зохион байгуулсан албан хаагчдын эрдэс бодисыг тодорхойлох шинжилгээнд хамрагдсан.</p> <p>7. Ажлын бус цагаар “Lawyers Community”-ийн “Цахим шилжилт ба хиймэл оюун ухаан” сэдэвт хэлэлцүүлэгт сонсогчоор оролцсон.</p> <p>8. Захиргааны удирдлагын газраас 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 9 цагт Монгол даатгал ХК-ны Ахлах андэрайтер В.Амарбаяр “Даатгал бидний амьдрал” сэдэвт мэдээллийн цагт хамрагдсан.</p> <p>9. Сангийн яамны Жендэрийн салбар зөвлөл”-ийн нарийн бичгийн даргатай 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдөр уулзаж зөвлөмж, зөвлөгөө, ажлыг чиглэл авсан.</p> <p>10. Жендэрийн Үндэсний Хорооноос “Жендэрийн мэдрэмжтэй ажлын байрны бодлогын хэрэгжилт, сайн туршлага” сэдэвт хэлэлцүүлэгт 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдөр оролцсон.</p> <p>11. Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн “Журам батлах тухай” 243 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Ахмад настанд дэмжлэг, хөнгөлөлт олгох журам”, 2 дугаар хавсралтаар батлагдсан “Ахмадын сан байгуулан ажиллуулах журам”, ГЕГ-ын даргын 2013 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн “Журам батлах тухай” А/187 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Гаалийн байгууллагын цахим сургалтын журам”, 2015.05.14-ны өдрийн “Журам батлах тухай” А/89 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Галийн байгууллагын ажилтныг гадаадад сургах, давтан</p>		
--	--	--	--	--	--	--	--

					<p>сруулах үйл ажиллагааг зохицуулах журам"-ыг уншиж, судалсан.</p> <p>12. 2025.04.18-ны өдөр Сургалтын төвийн дарга Ч.Мөнххишигийн "Гаалийн улсын байцаагчийн сэтгэл зүйн эрүүл мэнд" сэдэвт, Соёлын өвийн Үндэсний төвийн авран хамгаалах эрсдэлийн судалгааны газрын дарга Г.Анхсанаагийн "Соёлын өвийн тухай мэдлэг ойлголт" сэдэвт илтгэсэн мэдээллийн цагт сууж, мэдээ, мэдээлэл авсан.</p> <p>13. 2025.04.25-ны өдөр онц бөгөөд бүрэн эрхт элчин В.Энхболдын илтгэсэн "Д.Трампын тарифын бодлого ба олон улсын зах зээлийн хандлага", "МУИС-ийн Бизнесийн сургуулийн захирал Н.Батнасангийн илтгэсэн "Жижиг нээлттэй эдийн засгийн худалдааны бодлогын загвар ба тарифын зохицуулалт, анхаарах асуудлууд" сэдэвт мэдээллийн цагт сууж гадаад улсуудын цаг үеийн шинжтэй мэдээллийг авсан.</p>		
--	--	--	--	--	--	--	--

ТАЙЛАН ГАРГАСАН:
 ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ



Э.ДОЛГОРЖАВ 2025.06.10

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 8 дугаар хавсралт

ХҮНИЙ НӨӨЦ ХАРИУЦСАН ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ ЭРДЭНЭБАТЫН ДОЛГОРЖАВЫН 2025 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС (ГҮЙЦЭТГЭХ АЛБАН ТУШААЛТАН)

Байгууллагын нэр: ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

Нэгжийн нэр: ХҮНИЙ НӨӨЦИЙН ХЭЛТЭС

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4	5
	Оноо	60 хүртэл	10 хүртэл	70 хүртэл	
Зорилт 4. "Соён гэгээрүүлэх" арга хэмжээний биелэлт					
1.	Арга хэмжээ 1.1. Гаалийн байгууллагын албан хаагчдын хувийн хэргийн хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж хэрэгжүүлэх	50	5	55	
Зорилт 3. "Ногоон хөгжлийг дэмжиж, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх"					
2.	Арга хэмжээ 1.2. Гаалийн байгууллагын албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр түүнийг хэрэгжүүлж, төлөвлөгөөний биелэлтийг хариуцан ажиллах	58	9	67	
3.	Арга хэмжээ 1.3. Жендерийн дэд салбар зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулж, хэрэгжүүлэх	58	7	63	
4.	Арга хэмжээ 1.4. Хүний нөөцийн чиглэлээр албан хаагч, иргэдээс хандсан өргөдөл, гомдлыг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэсэн байх	58	9	67	
5.	Арга хэмжээ 1.5. Хүний нөөцийн үйл ажиллагаатай хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, эрх зүйн актыг мөрдөж ажиллах	60	10	70	
6.	Арга хэмжээ 1.6. Гаалийн байгууллагаас гарсан ахмадуудыг бүртгэх, судалгаанд хамруулах,	60	10	70	

2.	Багаар ажиллах	6
3.	Харилцаа	7
Дундаж оноо		6.6

5. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.)	66.1
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	12.3
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)	6.6
4.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)	6.6
5.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	
Нийт оноо = (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо (Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо		91.6

Үнэлгээ өгсөн:

Нэгжийн дарга:

ХҮНИЙ НӨӨЦИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

[Signature] Ж.БАЯСГАЛАН

2025.06.10 (огноо)

**Үнэлгээтэй танилцаж,
зөвшөөрсөн:**

Төрийн жинхэнэ албан хаагч:

ХҮНИЙ НӨӨЦ ХАРИУЦСАН
ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ

[Signature] Э.ДОЛГОРЖАВ

2025.06.19 (огноо)

Үнэлгээг хянасан:

Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:

ДЭД ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

[Signature] Г.ЭНХТАЙВАН

2025.06.25 (огноо)

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:


ХҮНИЙ НӨӨЦ ХАРИУЦСАН ГААЛИЙН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ

[Signature] Ө.ТЭГШЭЭ

2025.06.25 (огноо)

Үнэлгээг баталгаажуулсан: Төсвийн шууд захирагч

ДАРГА



(огноо)

2025.06.25